ХАРХОРИН СУМ

# ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

# ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян. төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ТӨРИЙН УДИРДЛАГА** | | | | | | | |
| **Зорилт 1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 1.1 | **Арга хэмжээ-1**<br>Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | 500,0 | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна. | Хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийг тухай бүр хяналтад авч ажиллалаа.<br>2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар Монгол Улсын хууль 1, Монгол Улсын Их Хурлын тогтоол 6, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 19, Ерөнхийлөгчийн зарлиг 5, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл 4, Засгийн газрын тогтоол 48, Ерөнхий сайдын захирамж 1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 43, Засгийн газрын албан даалгавар 5-ийг тус тус хяналтад авч, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг https://doc.main.mn/ цахим программаар тайлагнасан. | 100 |
| 1.2 | **Арга хэмжээ-2**<br>-Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | 100 |
| 1.3 | **Арга хэмжээ-3**<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, арга хэмжээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | | | | хэрэгжүүлсэн байна. | бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | |
| 1.4 | **Арга хэмжээ-4**<br>Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс сум орон нутагт хамаарал бүхий 29 зорилт арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.<br>2025 оны хэрэгжилт 91,0 хувийн биелэлттэй байна. | 100 |
| 1.5 | **Арга хэмжээ-5**<br>Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | 100 |
| 1.6 | **Арга хэмжээ-6**<br>Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | 100 |
| 1.7 | **Арга хэмжээ-7**<br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | 100 |
| 1.8 | **Арга хэмжээ-8**<br>Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний сум орон нутагт хамаарал бүхий зорилт, арга | - | 2024 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн | | 2025 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн | Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, арга хэмжээ бүрийг эзэнжүүлэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах | | | | хэрэгжүүлсэн байна. | хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. | |
| 1.9 | **Арга хэмжээ-9** Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийг байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах | 1000,0 | Сургалтын тоо | 69 | 75 | Эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт сурталчилгааг танхим болон олон нийтийн цахим хэрэгслээр иргэдэд хүргэн ажиллаж байна.<br>Энэ оны сүүлийн хагас жилийн байдлаар холбогдох албан хаагчидтай хамтран 9 удаагийн подкастыг бэлтгэн “Хархорин мэдээ” цахим хуудсаар.иргэдэд хүргэсэн нь нийт 47.4 мянган удаагийн хандалт, 2 удаагийн рийл бэлтгэн иргэдэд хүргэсэн нь 17.9 мянган удаагийн хандалтыг тус тус авсан байна.<br>Эрх зүйн боловсрол олгох чиглэлээр танхимын 19 удаагийн сургалтыг зохион байгуулж, 750 албан хаагчид, иргэд, хүүхэд залуучуудыг хамруулсан. | 100 |
| 1.10 | **Арга хэмжээ-10** “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн зохист тэнцвэрийг хадгалах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, энэ хүрээнд үг | - | Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байдал | | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажилласан байна | Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 02/14 тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | | | | | | |
| 1.11 | **Арга хэмжээ-11**<br>“Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолд заасны дагуу хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх бодлого баримталж ажиллах | 5000,0 | Хотоос тухайн суманд ирж суурьшсан иргэдийн тоо | - | Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогоор дэмжиж ажилласан байна. | Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 16/02 дугаар тогтоолоор батлагдсан "Нээлттэй Өвөрхангай" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт 19 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 90 хувийн хэрэгжилттэй байна.<br>2025 онд Улаанбаатар болон өөр аймаг сумаас 164 иргэн шилжин ирж суурьшлаа. | 90.0 |
| 1.12 | **Арга хэмжээ-12**<br>Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллага бүр Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, кибер аюулгүй байдлын дотоод журмыг баталж, мөрдөх | - | -Хуулийн хэрэгжилт<br>-Журам боловсруулан баталсан байдал | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, ил тод байдлын үзүүлэлтийг хангасан байна. | Засаг даргын Тамгын газрын даргын 20 дугаар тушаалаар кибер аюулгүй байдлын дотоод журмыг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 70.0 |
| 1.13 | **Арга хэмжээ-13**<br>Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах, Төрийн байгууллага, албан тушаалтанд хандан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэх процессыг хялбаршуулж, шийдвэрлэлтэд | - | -Хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй шийдвэрлэж, хариу өгсөн байдал<br>-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг даргын | | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өргөдөл, | Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой 56 иргэнээс хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд албан бичгээр 48 иргэнд хариу өгч, 8 шийдвэрлэх хугацаа болоогүй.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж байна.<br>Иргэдээс Нийгмийн даатгалтай холбоотой 430, нийгмийн халамжийн материал болон мөнгөн тусламж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүн шинжилгээ хийж, байгууллага, албан тушаалтны ажлын үр дүнг тооцох | | Тамгын газарт хугацаанд нь нэгтгэн хүргүүлсэн байдал | | гомдлын шийдвэрлэлтийг шуурхай шийдвэрлэж ажилласан байна. | хүссэн 1075, дэлгүүрийн зөвшөөрөл сунгах болон асуудал шийдвэрлүүлэх 23, тэтгэвэр тогтоолгох 200, газар өмчлөх ба эзэмшилтэй холбоотой 505, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 73, иргэний бүртгэлтэй холбоотой 346, нийт 2652 хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг улирал бүр гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж байна. Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 1716 өргөдөл ирсэн бөгөөд Нийгмийн халамжтай холбоотой 759, иргэний бүртгэл, төрөлт, шилжилт хөдөлгөөн, гэрлэлт, нас баралттай холбоотой 277, дэлгүүрийн зөвшөөрөл сунгах, асуудал шийдвэрлэхтэй холбоотой 13, Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 33, Газрын харилцааны чиглэлээр 221, Нийгмийн даатгалтай холбоотой 413 өргөдөл тус тус ирсэн. Үүнээс цахимаар 1273, биечлэн 443 өргөдөл ирж хуулийн хугацаанд шийдвэрлэлээ. | |
| 1.14 | **Арга хэмжээ-14** Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлэх | - | -Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх<br><br>-Хөндлөнгийн болон дотоод аудитаас гаргасан акт, албан | | Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төсвийн байгууллагуудад бүрэн хангуулж ажилласан байдал | | | | |
| **Зорилт 2.Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулан, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.** | | | | | | | |
| 2.1 | **Арга хэмжээ-15** Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, www.kharkhorin.gov.mn вэб сайтад мэдээллийг тухай бүр байршуулах | - | Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал | - | Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шуурхай, чирэгдэлгүй хүргэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж төрийн нэгдсэн цахим хуудас www.gov.mn 250 мэдээлэл оруулж, мэдээллээ ил тод байршуулан ажиллалаа. Төрийн байгууллагуудын үйлчилгээний мэдээллийг нэгтгэж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар хүргэсэн. | 100 |
| 2.2 | **Арга хэмжээ-16** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 68 мэдээллийг сумын байгууллага бүр олон нийтэд ил тод мэдээлэх, мөн shilen.gov.mn системд Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх | - | Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хувь | - | 100 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 68 мэдээллийг shilen.gov.mn системд "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу хугацаанд нь байршуулсан. "Ил тод байдлын самбар"-ын шинэчлэлтийн 7 хоногийн аяны хүрээнд төрийн байгууллагуудын ил тод байдлын самбарын мэдээллүүдийг шинэчлэх,байгууллагын танилцуулга, эрхэм зорилго, зорилт, хүний нөөц, сар, улирлын санхүүгийн мэдээлэл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журам"-ын дагуу байршуулж, үнэлүүлэх | | | | | авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, шилэн данс, зохион байгуулагдах үйл ажиллагааны хөтөлбөр, удирдамж зэргийг байршуулах, хугацаанд нь ил тод мэдээлэх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг мөрдөж ажиллах, shilen.gov.mn сайтад улирал бүр байгууллагынхаа мэдээллийн ил тод байдлыг үнэлүүлж, шивж мэдээллээ байршуулах талаар зөвлөгөө, мэдээллийг 13 байгууллагад хүргэж ажиллав. | |
| 2.3 | **Арга хэмжээ-17**<br>Байгууллагын удирдлагын системийг хэрэглээнд нэвтрүүлж, тоон гарын үсгийг ашиглаж, албан бичгийг цахимаар солилцож хэвших | - | Тоон гарын үсгээр баталгаажуулж, цахимаар илгээсэн албан бичгийн хувь | | 100 | ERP системийг хэрэглээнд нэвтрүүлж, төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны docx программд холбогдоод байна. | 100 |
| 2.4 | **Арга хэмжээ-18**<br>Go Uvurkhangai аппликэйшны хэрэглээг нэмэгдүүлж, иргэдийн цахимаар илгээж буй санал, хүсэлт, өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэх | - | -Go Uvurkhangai аппликэйшн хэрэглэгчдийн хувь<br>-Цахимаар ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал | | 100 | Go Uvurkhangai аппликэйшны хэрэглээний тухай Хархорин мэдээ фейсбүүк хуудас сумын албан ёсны цахим хуудас болох www.kharkhorin.ov.gov.mn сайтад байршуулж олон нийтэд мэдээлсэн.<br>2025 онд 15 мэдээлэл бүртгэгдсэнээс 10 асуудлыг газар дээр нь шийдвэрлэж, 5 асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлсэн. | 100 |
| **Зорилт 3.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.** | | | | | | | |
| 3.1 | **Арга хэмжээ-19**<br>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг бодитой үнэлж, "маш сайн" үнэлэгдсэн төрийн | - | -Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг | | -Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Монгол Улсын Засгийн | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2 зорилт, 26 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг авч, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | захиргааны албан хаагчдад байгууллагын зүгээс сургалтын төлберийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах<br>*(Төрийн албаны тухай хуулийн 55.3)* | | хэрэгжүүлсэн байдал<br><br>-Байгууллагаас дэмжлэг үзүүлж, мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан албан хаагчдын тоо | | газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна. | төлөвлөгөөний дагуу болон аймгийн сургалт, хөгжил хөтөлбөр, байгууллагын сургалтын төлөвлөгөөний хүрээнд мэргэжлийн бусад байгууллагатай хамтарсан болон байгууллагын дотоод 12 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1000 албан хаагч хамрагдлаа.<br>Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, мэргэжлийн чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан 4 албан хаагчийн сургалтын төлбөрт 1,8 сая төгрөг олгосон.<br>Төрийн анхан шатны үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай хууль тогтоомжийн талаарх ойлголт мэдээлэл өгөх, туршлага солилцох сургалтад 8 багийн Засаг дарга хамрагдлаа.<br>Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг бодитой үнэлж, “маш сайн” үнэлэгдсэн 33 албан хаагчдад 35,0 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олголоо.<br>Хотын захирагчийн албаны албан хаагчдад 5,2 сая төгрөгийн, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, ажлын хувцасаар хангаж, нийт албан хаагчдад 750,0 мянган төгрөгийн халуун аарц, чацаргана өгч ажиллалаа.<br>Засаг даргын Тамгын газрын 43 албан хаагчдад сар бүр 15,000 төгрөгийн хоолны хөнгөлөлт олгож, 70,950,0 мянган төгрөг зарцууллаа.<br>Нийт албан хаагчдыг Эрдэнийн болор толь эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 2560,0 мянган төгрөг зарцуулж, 7 албан хаагч өдрийн эмчилгээ, 4 албан хаагч дээд шатны үзлэг оношилгоонд хамрагдаж, дээд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатлалын эмнэлэгт эмчлүүлсэн 4 албан хаагчид 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан "Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт" сэдэвт сургалтад 300, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 310, Франц Улсын Аллиер мужаас ирсэн сэтгэл судлаач, секслогоч Алинэ Дупиктэй хамтарсан "Ажлын байран дээрх халшрах хам шинж" буюу "BURN OUT" сэдэвт сургалтад 200 гаруй төрийн албан хаагч тус тус хамрагдлаа.<br>Нэгдсэн эмнэлэг нийт 116 албан хаагчдад 54,6 сая төгрөгийн мөнгөн урамшуулал, ерөнхий боловсролын Орхон сургууль 40 багш, ажиллагсдад 58,6 сая төгрөг, ерөнхий боловсролын 2 дугаар сургууль104 багш, албан хаагчдад 100,0 сая төгрөг, ерөнхий боловсролын Гүнзгий сургууль 54 багш, албан хаагчдад 38,7 сая төгрөг, Номын хүрдэн сургууль 18 багш, албан хаагчдад 11,5 төгрөг, хүүхдийн 1,2,3,4,5 дугаар цэцэрлэг 57 багш, албан хаагчдад 52,7 сая төгрөгийн мөнгөн урамшуулал тус тус олголоо. | |
| 3.2 | **Арга хэмжээ-20**<br>Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын болон төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тооны захиалга ирүүлэх, нэр дэвшүүлсэн иргэн, албан хаагчийг хууль тогтоомжийн хүрээнд томилох, сул орон | - | -Сул орон тоог олон нийтэд ил тод мэдээлсэн байдал<br>-Сул орон тооны захиалгыг хуулийн хугацаанд ирүүлсэн байдал | | Төрийн албаны томилготой холбоотой шийдвэр хууль тогтоомжид нийцсэн байна.<br><br>Томилготой холбоотой гомдол, | Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоонд хууль бус томилгоо хийхгүй байх | | -Зөрчилтэй томилгоо хийгдээгүй байх<br>-Түр орлон гүйцэтгүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн байх | | маргаан гараагүй байна. | | |
| 3.3 | **Арга хэмжээ-21**<br>Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангаж, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах | - | -Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал<br>-Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал<br>-Нууцын баталгааг гаргуулсан байдал | | Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ыг мөрдөж ажилласан байна. | Хүний нөөцийн мэдээллийн системд бүртгэлтэй 44 албан хаагчийн мэдээллийг бүрэн шинэчилж, өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж, зөрчилгүй ажиллаж байна. Сүүлийн хагас жилд 43 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг нэг бүрчлэн системд оруулж, төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авсан. | 100 |
| 3.4 | **Арга хэмжээ-22**<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх | - | -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны тоо<br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх | - | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлийн үзүүлэлт буурсан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дагаж гарсан журмаар байгууллагын дарга, эрхлэгч нарт 1 удаа сургалт зохион байгуулсан. Төрийн албан хаагчдад зориулсан 2 удаагийн ёс зүйн сургалтыг зохион байгуулж, 51 албан хаагч хамрагдсан. Ёс зүйн дэд хорооноос албан хаагчдын дунд эерэг харилцаа, хандлагыг түгээх зорилгоор "Ёс-той Зүй-тэй" аяныг зохион байгуулж, сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. Үүний үр дүнд 2025 онд ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэсний хөтөлбөр 2024-2030<br>-Байгууллагын ёс зүйн дэд хороо, дотоод хяналт шалгалтын ажлын чанар | | | | |
| 3.5 | **Арга хэмжээ-23**<br>Нутгийн захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон багийн Засаг дарга нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын тоо<br>Багийн Засаг даргын тоо | | Төрийн албан хаагч 1<br><br>Багийн Засаг дарга 100 хувь | Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, мэргэжлийн чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан 4 албан хаагчийн сургалтын төлбөрт 1,8 сая төгрөг олгосон.<br>Төрийн анхан шатны үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай хууль тогтоомжийн талаарх ойлголт мэдээлэл өгөх, туршлага солилцох сургалтад 8 багийн Засаг дарга хамрагдлаа.<br>Төлөвлөгөөний хүрээнд энэ онд танхимын 64 удаагийн эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулж нийт 5928 иргэд, төрийн албан хаагчид, сурагчдыг хамруулсан байна.<br>Мөн Хархорин мэдээ фэйсбүүк хуудсаар "Хуулийн цаг" подкастын 17 дугаарыг бэлтгэн хүргэж, нийт 82,6 мянган удаагийн хандалт, 16 удаагийн рийл бичлэгийг хийж нийт 41,6 мянган удаагийн хандалтыг тус тус авсан байна. | 100 |
| 3.6 | **Арга хэмжээ-24**<br>Төрийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог олон нийтэд мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хэвшүүлэх | - | -Сул орон тоог нээлттэй зарласан байдал<br><br>-Сонгон шалгаруулалтын тоо | | -Сонгон шалгаруулалт-ыг ил тод, нээлттэй зохион байгуулж хэвшсэн байна.<br>-Томилгоотой холбоотой | Хотын захирагчийн албаны жолоочийн сул орон тооны зарыг сумын албан ёсны цахим хуудас болох www.kharkhorin.ov.gov.mn сайтад, Хархорин мэдээ фэсэбүүк хуудсаар байршуулж, олон нийтэд мэдээлж, сонгон шалгаруууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гомдол, маргаан гараагүй байна. | | |
| **ХОЁР.ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 4. Авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, сумдын төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх.** | | | | | | | |
| 4.1 | **Арга хэмжээ-25**<br>Сумын хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хамаарах заалт болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх байгууллагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах<br>Цахим хуудсанд байршуулж мэдээлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 87.0 | 89.0 | Авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг www.Kharkhorin.ov.gov.mn сайтад байршуулж, иргэд олон нийтэд мэдээлсэн.<br>Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфо график, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг тус тус kharkhorum.mn цахим хуудас, Хархорин мэдээ фэйсбүүк хаяг, сурталчилгааны самбарт байршуулж олон нийтэд хүргэж, 10,000 хандалт авлаа.<br>Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, болон Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах талаар гарын авлага бэлтгэн, 30 гаруй албан хаагчдад хүргэлээ.<br>"Тэвчье, сэргийлье" сургалт, сурталчилгаа, нөлөөллийн аяны хүрээнд Авлигын хор уршиг ба ангилал, Авлигыг хэрхэн хэмждэг вэ?, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан, нөхцөл сэдэвт гарын авлага бэлтгэн "Хархорин хууль эрх зүйн мэдээлэл", Хархорин мэдээ фейсбүүк хаяг, Насан туршийн суралцахуйн нэгжийн групп болон бусад 5 группт шэйр хийж олон нийтэд хүргэсэн. Мөн хуулийн цаг подкастаар "Авилгын эсрэг гэмт хэргийн тухай ойлголт болон эрүүгийн хариуцлага"-ийн талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн нь 2,9 мянган удаагийн хандалт авсан. | |
| 4.2 | **Арга хэмжээ-26**<br>Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг томилохын өмнө (түр орлон болон хавсран, туршилтын хугацаагаар) Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах. | - | Хуулийн хугацаанд ХАСУМ хянуулсан болон ХОМ гаргасан албан тушаалтны хувь | 100 | 100 | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах 8 багийн Засаг дарга, Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, томиллоо. Томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ гаргууллаа.<br>Мөн албан тушаалын ангилал зэрэглэл өөрчлөгдсөн 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянууллаа. | 100 |
| **Зорилт 5. Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам"-ын сумын Засаг даргад холбогдох заалтыг хэрэгжүүлж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж ажиллана.** | | | | | | | |
| 5.1 | **Арга хэмжээ-27**<br>Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам"-ын 2.3-д сум, баг, хорооны Засаг дарга хүний эрхийн төлөв байдлын тайланг аймаг, нийслэлийн Засаг | - | Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал. | | Хүний эрхийн төлөв байдлын тайланг хугацаанд нь ирүүлсэн байна. | Орон нутагт хүний эрхийг хангах дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж хугацаанд хүргүүлсэн. Өвөрхангай аймгийн Засаг даргын орон нутагт хүний эрхийг хангах дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг ханган ажиллалаа.<br>. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даргад тухайн жилийн 12 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж, 2025 оны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, тайлагнах | | | | | | |
| 5.2 | **Арга хэмжээ-28**<br>Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-г хэрэгжүүлж, (Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг төрийн байгууллагууд дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх) уг хуулийг судалж, төрийн албан хаагч, иргэдэд сургалт мэдээлэл зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх | - | -Дотоод журамд тусгасан төрийн байгууллагын тоо<br><br>-Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | -Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг төрийн байгууллагууд сумын ЗДТГ болон бусад төрийн байгууллагууд ын дотоод журамд тусгасан байна.<br><br>-500-аас доошгүй иргэнд сургалт мэдээллийг өгсөн байна. | Хүний эрхэд суурилсан хандлага сургалт хэлэлцүүлгийг хүний эрхийн комиссын Өвөрхангай аймгийн референт Туултай хамтран зохион байгуулсан.<br>Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, доктор, дэд профессор Б.Энхболдоор ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 05 дугаар сарын 20-21-ний өдөр тус суманд ажилласан. Төрийн албан хаагч, иргэдэд "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 310 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа. "Иргэдээ сонсъё" нэрлттэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өглөө. | 100 |
| 5.3 | **Арга хэмжээ-29**<br>Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх арга хэмжээг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | 100 | Хууль хяналтын байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийлээ. Өвөрхангай аймгийн Хархорин суманд зохион байгуулсан "Хүний эрхийн төлөө хамтдаа" нэрлттэй өдөр арга хэмжээний хүрээнд Сум дундын Шүүхийн Тамгын газар, Прокурорын газар, Цагдаагийн хэлтэс, ШШГХ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн удирдлага, Нэгдсэн эмнэлэг, Ерөнхий боловсролын Орхон сургууль зэрэг албан байгууллагуудын албан хаагчидтай ХЭҮК-ын гишүүн Б.Энхболдоор ахлуулсан ажлын хэсэг уулзалт зохион байгууллаа. | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэхэд хүний эрх хэрхэн хангагдаж байгаа талаар хяналт шалгалтыг явуулж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Монгол Улс, Франц Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, Өвөрхангай аймаг, Франц Улсын Аллиер мужтай найрсаг харилцаа тогтоосны 25 жилийн ойн арга хэмжээний ажлын хүрээнд Франц Улсын Аллиер мужаас ирсэн сэтгэл судлаач, сексологич Алинэ Дупик "Ажлын байран дээрх халшрах хам шинж" буюу "BURN OUT" сэдвээр төрийн албан хаагч нарт сургалт зохион байгууллаа. Сургалтад Засаг даргын Тамгын газар, Сум дундын Прокурорын газар, Шүүхийн Тамгын газар, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Онцгой байдлын хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны алба хаагчид, Ерөнхий боловсролын 4 сургууль, 5 цэцэрлэгийн багш, ажилчид нийт 200 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. | |
| 5.4 | **Арга хэмжээ-30**<br>Хүний эрхийн Олон улсын тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр төлөвлөгөө (жилийн турш хэрэгжүүлэх) батлан төрийн албан хаагчид, олон нийтийн хүний эрхийн боловсрол, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, сургалт | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | 100 | Төрийн албан хаагч, иргэдэд "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 310 төрийн албан хаагч, иргэд хамрагдлаа.<br>Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерийн хорооноос жил бүр зохион байгуулдаг "Харилцан хүндэтгэе" 1 сарын аяныг "Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе" уриатайгаар зохион | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийг арга хэмжээ зохион байгуулах | | | | | байгуулж "Жендерт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан", эмэгтэйчүүдэд зориулсан "Өөрийгөө хайрлахуй" сэдэвт сургалт, "Хайраа хайрлая" сэдэвт гэр бүл рүү чиглэсэн сургалт зохион байгуулагдлаа.<br>Нийт 60 иргэн хамрагдлаа. | |
| **Зорилт 6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгож, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 6.1 | **Арга хэмжээ-31**<br>Гамшгаас хамгаалах, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн чадавхыг дээшлүүлж техник, тоног төхөөрөмжөөр хангах | - | -Зарцуулсан хөрөнгийн дүнгээр<br>-Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | | -Шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангадсан байна.<br>-Сайн дурын хэсгийн чадавх сайжирсан байна. | Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/77 тоот захирамжаар Гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.<br>Өвөрхангай аймгийн Онцгой байдлын Газраас зохион байгуулагдсан "Эрсдэлгүй маргааш" цахим сургалтанд 11 иргэнийг хамруулж "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам"-ыг танилцуулав. Сайн дурын хэсгийн хүч хэрэгслийн судалгааг нарийвчлан 10 байгууллагын 54 авто техник хэрэгсэл, 79 хүн хүч, эмнэлэгийн хэрэгсэлийн анхан тусламжийн хайрцаг, хэрэглэгдэхүүн судалгаа гарган нэгтгэлээ.<br>Дуут дохио, цахилгаан үүсгүүр, хүрз, хувин, галын хор,хөрөө, жоотуу, үлээгч, каск зэрэг шаардлагатай багаж, төхөөрөмжийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| **ГУРАВ.БАТЛАН ХАМГААЛАХ, ОНЦГОЙ БАЙДЛЫН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 7. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.** | | | | | | | |
| 7.1 | **Арга хэмжээ-32**<br>Цэргийн насны болон өсвөр насны залуучуудын дунд эх оронч үзэл, хүмүүжил олгоход чиглэсэн 2-оос доошгүй | 1000,0 | Хамрагдсан иргэдийн тоо | - | 100-аас доошгүй иргэнийг хамруулсан байна. | Насан туршийн суралцахуйн нэгжтэй хамтран хамтран Цэргийн насны залуучуудын дунд "Эрүүл чийрэг эр хүн" сэдэвт сургалт 2 удаа зохион байгуулж, 75 залуу,"Мэргэжил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах | | | | | сонголт" "Харилцаа хандлага" "Эх орончуудэл " сэдэвт сургалт зохион байгуулж ахлах ангийн 200 гаруй сурагчид тус тус хамрагдлаа. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Эрчүүдэд тулгамдаж буй асуудал", Гэр бүл салалт", "Харилцаа ба хандлага" "Гэр бүлийн тухай" сургалт зохион байгуулж, 150 залуучууд хамрагдлаа. | |
| **Зорилт 8. Иргэдэд Батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэж ажиллана. (Цэргийн бүртгэл, цэрэг татлага, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх)** | | | | | | | |
| 8.1 | **Арга хэмжээ-33** Ээлжит цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт нь дэмжлэг туслалцаа үзүүлэх | 2500,0 | Цэрэг татлагад хамрагдах иргэд болон хяналтын тооны биелэлтийн хувиар | 90 | Цэрэг татлагад иргэдийн 90-ээс доошгүй хувийг хамруулан хяналтын тоог биелүүлнэ. | 2025 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, цэрэг татлагад тус бүр 300 залуу хамрагдаж, 15 залуу цэргийн албанд морьдсон. | 100 |
| 8.2 | **Арга хэмжээ-34** Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн судалгааг гаргаж, төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах | - | Мөнгөн төлбөр төлүүлэх хүний тоогоор | 7 | 3-аас доошгүй иргэнээр мөнгөн төлбөр төлүүлсэн байна. | Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийн судалгааг гаргаж, **5** иргэнээр **10,596,819** төгрөгийн төлбөр төлүүллээ. | 100 |
| **Зорилт 9. Дайчилгааны төлөвлөгөө болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.** | | | | | | | |
| 9.1 | **Арга хэмжээ-35** Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Өвөрхангай аймгийн "Улсын дайчилгааны төлөвлөгөө" батлагдсантай уялдуулан сумын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах | - | -Дайчилгааны төлөвлөгөөнд шаардагдах мэдээллийг техник, эдийн засгийн үндэслэлтэй боловсруулах -Орон нутгийн онцлог, хүн амын болон эдийн засгийн | | Сумын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулсан байна. | Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/202 дугаар захирамжаар сумын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Төлөвлөгөөнд шаардлагатай суурь судалгааг гаргаж, төлөвлөгөөний төсөл боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байдалтай сайтар уялдуулах | | | | |
| 9.2 | **Арга хэмжээ-36**<br>Сумын цэргийн дайчилгааны төлөвлөгөөг үндэслэн сумын батлан хамгаалах товчоо, цугларах, шилжүүлэх байрын бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага зохион байгуулан явуулах | - | Сургалт, дадлагыг зохион байгуулан баримт бичгийг шинэчилсэн байдлаар | | Сургалт, дадлага зохион байгуулж, баримт бичгийг шинэчилсэн байна. | - | |
| **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 10. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлогыг төлөвлөх, улс, аймаг, сум, байгууллагын төсвийн орлогын төлөвлөгөөг хангах биелүүлэх, Татварын тухай хууль тогтоомжийг сурталчлан, хуулийн этгээдийг татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулж, татварын бааз суурийг өргөтгөх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 10.1 | **Арга хэмжээ-37**<br>Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж төсвийг батлуулах, хуулийн дагуу төсвийн тодотгол хийх | - | -Жилийн төсвийн төсөл<br>-Төсвийн тодотголын тооцоолол) | | Жилийн төсвийг хуулийн дагуу батлуулсан байна.<br>Төсвийн тодотголыг тухайн цаг хугацаанд хийсэн байна. | Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 02/14 тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа. | 100 |
| 10.2 | **Арга хэмжээ-38**<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан аймгийн болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх | - | Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлгийн биелэлтийн хувиар | 100 | 100 | Аймгийн төсөвт АТБӨЯХАТ-т 78,958,106 зам ашигласны төлбөр 23,392,013 төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллалаа. | 100 |
| 10.3 | **Арга хэмжээ-39**<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын хэмжээг тогтоох тухай" 08/04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг | - | -Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал<br><br>-Газрын төлбөрийн | | Газрын төлбөрийн орлогын биелэлтийг бүрэн хангахад хуулиар олгосон эрх, үүргийнхээ | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын хэмжээг тогтоох тухай" 08/04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж, 2025 оны газрын төлбөрийг газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд газар эзэмшигч иргэн, аж | 70.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж, газрын төлбөрийн орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллах | | орлогын биелэлтийн хувь | | хүрээнд хяналт тавьж ажилласан байна. | ахуй нэгж байгууллагын 1639 нэгж талбарт 249,1 сая төгрөгийн оногдуулалт хийж, нэхэмжлэл үүсгэн татварын тасагт хүргүүлж, төвлөрүүлэх ажлыг зохион байгууллаа.<br>Газрын төлбөрийн орлогын биелэлт 79 хувьтай биелсэн. | |
| 10.4 | **Арга хэмжээ-40**<br>Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг иргэдэд сурталчлан таниулж хэрэгжилтийг хангаж, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх | - | Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувь | | Орлогын төлөвлөгөөний биелэлт | Малын тоо толгойн албан татварт 187,617,416 төгрөгийг төвлөрүүлэн, төлөвлөгөөг 125 хувиар биелүүллээ.<br>Урд оны татварын үлдэгдэлтэй 470 татвар төлөгчийн 120,800,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч ажиллалаа.<br>Үүний үр дүнд 114 татвар төлөгчийн 93,0 сая төгрөгийг төвлөрүүллээ. | 100 |
| **Зорилт 11.Төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулан, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж, төсвийн жилд өр төлбөргүй ажиллана.** | | | | | | | |
| 11.1 | **Арга хэмжээ -41**<br>"Хоршоо хөгжүүлэх сан"-гийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах | - | Гэрээний хугацаа хэтэрсэн, найдваргүй зээлийн үлдэгдэл (төгрөг), гэрээний хугацаа хэтрэлт, найдваргүй зээлийн хувийн жин (хувиар) | 5.2 | Гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн үлдэгдлийг 30 хувиар бууруулж, гэрээний хугацаа дуусгавар болсон, найдваргүй зээлийн хувийн жин 4.7 хувьд хүргэсэн байна. | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 03/05 дугаар тогтоолоор Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах тов тогтоосон.<br>төсөл хүлээж авах тухай мэдээллийг Хархорин мэдээ фэйс бүүк хуудас, албан ёсны цахим хуудас, www.kharkhorin.ov.gov.mn сайтаар 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 28-ний хүртэл олон нийтэд мэдээлж, сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/95 дугаар захирамжаар газар тариалан малын тэжээлийн үйлдвэр байгуулах, оёдлын цех, ажлын байр барих, цэвэр усны үйлдвэр өргөтгөх тоног төхөөрөмж шинэчлэх чиглэлээр 3 хоршоонд 470,0 сая төгрөгийн зээл олгож 26 байнгын болон түр ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байр бий болж зээлийн хугацаа хэтрэлт 09 хувьд хүрлээ.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар 27 зээлдэгч, үүнээс 11 аж ахуйн нэгж, хоршоо, 16 иргэн 1,120,2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна. | |
| 11.2 | **Арга хэмжээ -42**<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээлэл байршуулалтын чанарыг сайжруулах | - | Мэдээлэл байршуулалт, мэдээ илгээлт (хувиар) | 99.0 | Мэдээлэл байршуулалт, улирлын мэдээ илгээлтийг 100 хувьд хүргэсэн байна. | Шилэн дансны цахим мэдээллийн системд төсөвт 22 байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 1 байгууллага, сумын тусгай 3 сангийн 4 төрлийн 151 мэдээлийг хугацаанд оруулж мэдээлсэн. хугацаандаа байршуулан ажиллалаа.<br>Сумын хэмжээнд мэдээлэл огт байршуулаагүй байгууллага байхгүй. | 100 |
| 11.3 | **Арга хэмжээ-43**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, орон нутгийн өмчийн талаар мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг мөрдлөг болгон, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хантан ажиллаж, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлэх | - | Тайлант онд шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгасан хувь | 80.0 | 100 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, орон нутгийн өмчийн талаар мөрдөгдөж байгаа дүрэм журмуудыг мөрдлөг болгон, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>Энэ онд "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-ийн программ хангамжийг нэвтрүүллээ. | 100 |
| 11.4 | **Арга хэмжээ-44**<br>Орон нутгийн харьяалалтай аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авалт, баталгаажуулалтын түвшинг 100 хувиас доошгүй хувьд хүргэж, тайлан хүлээн авалтын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, | - | Тухайн суманд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгуулагын тоо | 95 хувь | 100 хувь | Орон нутгийн харьяалалтай аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан хүлээн авалтын мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн сангийн хэлтэст хүргүүлэх | | | | | | |
| **Зорилт 12. Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулна.** | | | | | | | |
| 12.1 | **Арга хэмжээ-45**<br>Албан ёсны статистик мэдээ, тайланг графикийн дагуу үнэн зөв цуглуулах, хугацаанд нь программд оруулж буй эсэхэд хяналт тавьж ажиллах | - | -Графикт мэдээний тоо, чанар<br>-Программд хугацаанд нь шивсэн эсэх | 100 хувь | Аймгийн Статистикийн хэлтсийн даргын 2022 оны А/01 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу хамралт 100 хувьтайгаар мэдээг үнэн зөв цуглуулж, хугацаанд нь программд шивж оруулсан байна. | Сум, багийн хүн ам, өрхийн мэдээллийг Хүн, ам өрхийн мэдээллийн санд тухай бүр үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийж ажиллаж байна. Аймгийн Статистикийн хэлтсийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу анхан шатнаас цуглуулах статистик мэдээ, тайланг Статистикийн хуулийн дагуу сар, улирал бүр (ХАА1-8, СХ, АҮ, ТББ, МЭ, ЗГ, Т, ББО, А-ОС3, А-ОС4, ХҮИ) иргэн аж ахуй нэгж бүрээр цуглуулан програмд шивж, Статистикийн хэлтэст хүргүүлсэн. | 100 |
| 12.2 | **Арга хэмжээ-46** Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, тогтмол баяжилт хийх | - | Хүн ам, өрхийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт хийсэн тоо | 100 хувь | Сумын хүн ам, өрхийн мэдээллийн санд баяжилт хийж, шинээр төрсөн хүүхдийн мэдээллийг нэмж, нас барсан хүний мэдээллийг хассан байна. | Хүн, ам өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, өрх, хүн амын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн, төрөлт нас баралт, өрхийн байршил зэргийг цаг тухай бүр мэдээллийн санд оруулж баяжилт хийн ажилласан. | 100 |
| 12.3 | **Арга хэмжээ-47**<br>Улсаас явагдаж байгаа тооллого судалгаа болон хагас, бүтэн жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах, боловсруулах, үр дүнг мэдээллэх. | 3500,0 | Тооллого, судалгааг хугацаанд нь чанартай зохион байгуулах, үнэн зөв бодит байдлыг хангах | 100 хувь | Сумын нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтдыг жилийн эцсийн тооллогод | Засаг даргын А/101 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулж, хагас жилийн малын түүвэр судалгааг журам, заавруйн дагуу зохион байгуулж, хяналтын тооллого явуулан үр дүнг боловсруулж, хугацаанд нь програмд шивж оруулан сумын Засаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд нь 100 хувь хамруулж, үр дүнг боловсруулан, тархаасан байна. | даргад танилцуулан дүн, тайлан мэдээг Статистикийн хэлтэс болон Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн Хагас жилийн малын түүвэр судалгаанд 8 багийн 252 өрх хамрагдаж адуу-7614, үхэр 7219, тэмээ 1, хонь 32829, ямаа- 17210 нийт 64873 мал тоологдож, Мал тооллогын програмд шивж оруулсан. | |
| **Зорилт 13. Орон нутгийн өмчийн ашиглалт захиран зарцуулалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн өмчийн хяналтыг хэрэгжүүлэх, өмчийн ашиглалт эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 13.1 | **Арга хэмжээ-48**<br>Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт шалгалтын ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоогоор | | 4-өөс доошгүй | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, бүртгэл, ашиглалт, захиран зарцуулалтад хяналт тавин ажиллаж, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хурлын 02/06 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын Гүнзгий сургууль, Спортын ордон, ерөнхий боловсролын Орхон сургуулийн ашиглах боломжгүй 56 нэр төрлийн 86,188,464.8 төгрөгийн хөрөнгийг акталсан. | 100 |
| 13.2 | **Арга хэмжээ-49**<br>Улсын хэмжээнд нэгдсэн журмаар хэрэгжүүлж байгаа "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-ийн программ хангамжийг ашиглалтад бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг сумандаа зохион байгуулж, Орон нутгийн өмчийн газартай хамтран ажиллах | - | Мэдээллийн сангийн дүүргэлт хийсэн байгууллагын тоогоор | | Төсөвт байгууллагын тоогоор | Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/168 дугаар захирамж төрийн болон орон нутгийн өмчийн ажлын хэсэг байгуулан "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-ийн программ хангамжийг нэвтрүүллээ.<br>Засаг даргын Тамгын газрын 22,673,878,737.63 төгрөгийн хөрөнгийг цахим бүртгэлд шивж оруулсан. Үүнд барилга байгууламж 19,567,209,385, тээврийн хэрэгсэл 582,628,061, Тавилга эд хогшил 188,464,362, бусад үндсэн хөрөнгө 749,663,635, биет бус хөрөнгө 11,514,477 төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэсэн. Хотын захирагчийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албанд 2,217,583,573.56, төгрөгийн хөрөнгийг цахим бүртгэлд шивж оруулсан. Үүнд<br>биет бус хөрөнгө 117,040,000, Барилга байгууламж 2,018,937,519, тээврийн хэрэгсэл 37,500,000, Тавилга эд хогшил 44,108,054 төгрөгийн хөрөнгө тус тус бүртгэсэн. | |
| 13.3 | **Арга хэмжээ-50**<br>Орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, өмчийн зохицуулалтын талаар мөрдөгдөж байгаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журам, аргачлал, зааврууды мөрдөж ажиллах, хэрэгжилтийг хангуулах | - | Батлагдсан 4 журам, аргачлалын биелэлтийн хувиар | - | 100 хувь | Аймгийн ИТХурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 24/021 дугаартай тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах ,бүртгэх данснаас хасах шилжүүлэх журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмж, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг актлах тухай өмч хамгаалах зөвлөлд хүсэлт хүргүүлэн, машин тоног, төхөөрөмж дагалдах хэрэгсэл болох 4,705,500 төгрөгийн үнэ бүхий принтер 3 ширхэг, нөүтбүүк 2 ширхэг, тавилга эд хогшил болох 1,424,726 төгрөгийн өртөг бүхий 17 ширхэг хөрөнгийн актлах тухай саналаа Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд уламжлахаар шийдвэрлэлээ. | 100 |
| 13.4 | **Арга хэмжээ-51**<br>"Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих журам"-ын дагуу төрийн байгууллагуудтай байгуулсан "Орон нутгийн өмчийг | - | Дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн хувиар | - | 100 | "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих журам"-ын дагуу "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 92 хувиар дүгнүүлсэн. | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн зөвлөмж, шаардлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | | |
| **ТАВ. СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 14. Бүх нийтийн соёлын боловсрол олгох ажлын хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.** | | | | | | | |
| 14.1 | **Арга хэмжээ-52**<br>Өндөр гэгээн Занабазарын түүхт 390 жилийн ойг тохиолдуулан хүүхэд, залуучуудад түүхэн хүмүүний намтар түүх, соёлын өвийг сурталчлан түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3 | Өндөр гэгээн Занабазарын 390 жилийн ойг угтан "ӨНДӨР ГЭГЭЭНИЙХЭЭ ӨВИЙГ ДЭЭДЛЭН ӨНӨД ЭГШИГЛЭХ ХУУРАА ХӨГЛӨЕ" арга хэмжээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Шанхын баруун хүрээ хийдийн тэргүүн лам Н.Баасандорж Өндөр гэгээний түүх, зураач Ц.Пүрэвнамбар Өндөр гэгээний намтар уран бүтээлийн талаар, Эрдэнэзуу хийдийн голч лам Ч.Гонгор Жанлавцогзол номын талаар сургалт, мэдээлэл хийж, 8-12 дугаар ангийн 70 гаруй сурагчид хамрагдлаа.<br>Өндөр гэгээн Занабазарын намтар уран бүтээл түүх соёлын тухай гэрэл зураг болон номын үзэсгэлэнг дэлгэн иргэд олон нийтэд танилцууллаа.Тус арга хэмжээний үеэр "Өнөд эгшиглэх хуураа хөглөе" ажлыг зохион байгуулж морин хуурч Ц.Пүрэв шавь нарын хамт айл өрх албан байгууллагын морин хуурыг хөглөж эгшиглүүллээ.Арга хэмжээг Хархорин сумын Соёлын төв, Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Эрдэнэзуу музей<br>Эрдэнэзуу хийд, Шанхын баруун хүрээ хийд хамтран зохион байгууллаа.<br>Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойд зориулсан "Алтан соёмбо мину" боловсрол танин мэдэхүйн ажлыг зохион байгуулав. Танин | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдэхүйн ажлын хүрээнд Өндөр гэгээн Занабазарын намтар уран бүтээл түүнтэй холбоотой Орхоны хөндийд орших сүм хийд, түүний зохиосон Соёмбо үсгийг утгыг тайлбарлаж, дүрслэлийн онцлогийн талаар 200 гаруй сурагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав | |
| 14.2 | **Арга хэмжээ-53**<br>"Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2025"-ыг зохион байгуулж, номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутагт туршлага болохуйц арга хэмжээг сурталчлан түгээн дэлгэрүүлэх | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 4 | Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд-2025" арга хэмжээний хүрээнд "Илүү их уншъя" 2 сарын аян зохион байгууллаа. "Бүтээлч уншлага" үйл ажиллагаа зохион явуулж, 596 уншигч хамрагдсан. Аяны хаалтын үйл ажиллагааны үеэр 6 гэр бүлийн дунд "Эерэг энерги түгээе" номын хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>2025 онд гэрээр-256, танхимаар 122, ирэгсэд-439, нийт 817 иргэн ном уншиж, байнгын уншигч 301 боллоо.<br>1000 ном хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн 4-5 насны багачуудад зориулсан "Чанга уншлага үлгэр унших, ярих", "уншъя хөгжье" арга хэмжээ сургуулийн сурагчид, анги хамт олноороо ном унших, ярих, хэлэлцүүлэг хийлээ.<br>"Шүлэгч анги" челленж 1-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж давхардсан тоогоор 2000 гаруй сурагчид хамрагдсан. | 100 |
| 14.3 | **Арга хэмжээ-54**<br>Сүм хийд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэн баримтжуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах | - | Бүртгэсэн баримтад өвийн тоо | - | 5 | Хархорин сумын сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран 40 иргэний соёлын үнэт зүйлийн судалгааг гарган авч баримтжуулсан. Шанх багийн 1 иргэний эртний зурмал бурхныг маягтын дагуу бүртгэн баримтжуулж, аймгийн музейн бүртгэл мэдээллийн санд хүргүүллээ.<br>Орон нутаг судлах танхимд шинээр 3 үзмэр бүртгүүлж, сумын түүхэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | замналтай холбоотой Баярын бичиг, өргөмжлөл, САА-ын тамга зэргийг маягтын дагуу бүртгэн баримтжуулж, үзмэрийн тоог нэмэгдүүлэхээр аймгийн музейн захиргаанд хүсэлтээ хүргүүлсэн. | |
| 14.4 | **Арга хэмжээ-55**<br>Үндэсний, уламжлалт хоол идээ ундаа улирлын онцлогт тохируулан сэргээн уламжлуулах ажлыг зохион байгуулах | | -Уламжлалт хоол, идээ ундааны төрөл зүйл, хамрагдсан хүний тоо,<br>-Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5 | "Хархорины намар-2025" үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, үзэсгэлэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 5 хоршоо, 46 иргэн 121 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 21,7 сая төгрөгийн борлуулалт хийлээ. | 100 |
| **Зорилт 15. Хархорин сумын Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 15.1 | **Арга хэмжээ-56**<br>Торгоны зам-Хархорум хот соёл аялал жуулчлалын фестивалийг аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран зохион байгуулж, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | - | Жуулчдын тоо | 3500 | 4500 | - | |
| **Зорилт 16. Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр** | | | | | | | |
| 16.1 | **Арга хэмжээ-57**<br>"Залуучуудын соёлын фестиваль"-ыг нутаг дэвсгэрийнхээ хүрээнд зохион байгуулах | - | Фестивальд оролцсон залуучуудын эзлэх хувь | | Сумын залуучуудын 70-аас доошгүй хувийг хамруулсан байна | - | |
| 16.2 | **Арга хэмжээ-58**<br>Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах | - | Хамрагдсан залуучуудын тоо | 50 | 100 | Анхдугаар Үндсэн хуулиа баталж, Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан иргэний андгай өргөх ёслолыг зохион байгууллаа. Иргэний андгай өргөх ёслолд 16 нас хүрч иргэний үнэмлэхээ гардан авч буй 66 сурагч оролцон иргэний андгай өргөлөө. | 100 |
| 16.3 | **Арга хэмжээ-59** | - | -Дэмжлэг үзүүлсэн байдал | 1 | 3 | Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг сумын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, Залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах | | -Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | | | Засаг даргын 2025 оны А/183 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.<br><br>Залуучуудыг хөгжлийн салбар зөвлөлөөс энэ онд Хархорин марафон, Хүүхдийн баяр, Намрын ногоон өдрүүд зэрэг арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, залуучуудын оролцоог хангахад анхаарч ажилллаunion. Мөн Монголын Залуучуудын Холбооны Хангайн бүсийн чуулга уулзалыг Хархорин суманд зохион байгуулахад хамтран оролцож, Баянхонгор, Өвөрхангай, Архангай аймгуудын нийт 80 гаруй залуучууд чуулганд оролцсон. | |
| **ЗУРГАА. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 17. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах, түүхий эд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 17.1 | **Арга хэмжээ-60**<br>Өвөлжилтийн бэлтгэл ажил, өвс тэжээлийн аюулгүй нөөцийн бүрдүүлэлтийг хангаж ажиллах | - | Биелэлтийн хувиар | 82.5 | 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 85 хувиас доошгүй хангасан байна. | Сумын аюулгүй нөөцөд өмнөх оны 1600 (40 тн) боодол ногоон тэжээл үлдэгдэлтэй, 2025 онд орон нутгийн хөгжлийн сангийн 64,5 сая төгрөгөөр 62,5 тонн (2500 шуудай) хивэг, 25 тн (1000 боодол) өвс худалдан авч нөөц бүрдүүллээ.Сумын аюулгүй нөөцөд 127,5 тн өвс, тэжээлийн нөөцтэй байна. | 100 |
| 17.2 | **Арга хэмжээ-61**<br>Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготнотой микробиологийн болон энгийн механик биологийн аргаар ургамал хамгааллын ажлыг зохион байгуулах | 75500,0 | Талбайн хэмжээ | 1000 | .... мянган га-д мэрэгч устгалын ажил зохион байгуулсан байна. | Засаг даргын А/48 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая, улсын төсвийн 52,5 сая, газрын дуудлага худалдааны 2,8 сая, нийт 75,3 сая төгрөгийн санхүүжилтээр Нарийн хүр багийн Өртөө гарам, Талын дөрвөлжин, Зүүн намаг, Онгоцон ухаа багийн Хадан хошуу, Зогсоол толгой, Худаг элстэй, Ар элстэй, Улаан худаг, дөрөлжин, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цагаан нуур, Жалбаа багийн Тасархай,Тариат, Тодон, Өвөр элстий, Шанх багийн Шар бүрд, Дүгрэг, Өлзийт овоо, Сарын гол, Өрхтий, Хөшөөн дэнж, Таван цохио, Голын овоот, Дэрсэн худаг, Бумбат орчмын 4,9 мянган га бэлчээрийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд микробиологийн аргаар хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажил зохион байгуулж, 88,2 хувийн үр дүнтэй хүлээлгэн өгсөн. | |
| 17.3 | **Арга хэмжээ-62**<br>Нийт хээлтүүлэгч болон эрчимжсэн аж ахуйн үхэр, цөм сүргийн малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлт, баяжилт, ашиглалтыг сайжруулах | - | Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн малын тоогоор | - | -Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн шинэчлэлт, баяжилтын ажлыг бүрэн хийж дуусгасан байна.<br>-Эзэмгжүүлсэн малыг бүрэн программд оруулсан байна. | Малын үндэсний бүртгэл мэдээллийн санд 1117 малчин өрх, мал бүхий 110 өрхийн мэдээллийг шинэчлэн баяжилт хийлээ. Энэ онд нийт 2523 хээлтүүлэгч тоологдсоноос буур 6, азарга 946 бух 336 хуц 785 ухна 450 тоологдсон. | 100 |
| 17.4 | **Арга хэмжээ-63**<br>Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих, бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх | - | "Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж"-д ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгчийн тоогоор | - | Стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийг малчдад нийлүүлсэн байна. Мал үржүүлэг технологийн нэгжийг дэмжиж, хамтран | Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжүүдтэй хамтран эрчимжсэн аж ахуйн 138 үхрийг эзэмгэлж, мөн богийн 3 суурь дээр ангилан ялгалт хийж 286 хээлтүүлэгч малыг эзэмгжүүлэн, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэв.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгөөр 60 тооны барга үүлдрийн хуц худалдан авч, ялган суурилууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан байна. | | |
| **Зорилт 18. Атрын 4 дүгээр аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, усалгаатай тариалан эрхлэх үйл ажиллагааг дэмжинэ.** | | | | | | | |
| 18.1 | **Арга хэмжээ-64**<br>Тариалангийн эргэлтийн талбай, тarимлын төрөл, ургацын хэмжээг нэмэгдүүлэх | - | -Тариалсан талбай га, хураасан ургац тн-оор<br>-Нэмэгдүүлсэн талбайн хэмжээ га | - | Газар тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Энэ онд 3875 га талбайд 3 төрлийн үр тарианы ургамал, 3120 га талбайд тосны ургамал, 221 га талбайд төмс хүнсний ногоо, 3505 га талбайд тэжээлийн ургамал, 10206 нийт 7206 га талбайд тариалалт хийгдэж, 4600 га талбайд уриншийн боловсруулалт хийлээ.<br>Нийт 13,3 мянган га талбайд тариалалт 1800 тн үр тариа, 1200 тн тосны ургамал, 5400 тн тэжээл, 1620 тн төмс хүнсний ногоо хураан авлаа.<br>Тус онд атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 380 га атаршсан талбайг малчдад, малчдын 5 хоршоонд ногоон тэжээл тариалах зориулалтаар 40 га газрыг тус тус олгосон. | 100 |
| 18.2 | **Арга хэмжээ-65**<br>Газар тариалангийн зориулалттай техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, шинэчлэл хийх, төмс, хүнсний ногооны механикжуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - | -Шинээр нэмэгдүүлсэн техник, тоног төхөөрмжийн тоо,<br>-Засаж сайжруулсан техник, тоног төхөөрмжийн тоо | - | 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн (Малын тоо толгойн албан татварын орлого) 183,6 сая төгрөгийн санхүүжилтээр малын тэжээлийн ургамал тариалах иж бүрэн трактор, хаман боогч, үрлэгч (3 агрегат) анжис, хадуур тармуур худалдан авлаа. | 100 |
| 18.3 | **Арга хэмжээ-66**<br>Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг дэмжих | - | -Шинээр нэмэгдсэн хүлэмжийн тоо $м^2$,<br>-Дэмжигдсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо,<br>-Тариалсан талбай, га | - | Хүлэмжийн тоо, тариалсан талбай, хураан авсан ургац өссөн байна. | Суманд 64 $м^2$ зуны нийлэг хальсан хүлэмж, 800 $м^2$ өвлийн хүлэмж ашиглалтад орж, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн хүрээнд олгогдсон 32 $м^2$ хүлэмжийг уралдаанд тэргүүлсэн 2 иргэнд ашиглалтын гэрээгээр эзэмшүүлж, барьж байгуулан 2 дахь жилдээ тариалалт хийж ургацын хэмжээ нэмэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Хураасан ургац тн | | | Мөн суманд "Мойлт ундарга" ХХК нь 200 сая төгрөгийн санхүүжилтээр 800 м² өвлийн хүлэмжийг "Бат хүлэмж" ХХК-иар бариулан ашиглалтад оруулж, үйл ажиллагаа нь тогтворжиж тариалалт хийгдсэнээр ургацын хэмжээ нэмэгдсэн байна.<br>Хувийн 25,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 64м2 зуны хүлэмж ашиглалтад орж, тариалсан талбай нэмэгдлээ. | |
| 18.4 | **Арга хэмжээ-67**<br>Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах | - | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ га-аар | | 10 га талбайд ойн зурвас байгуулсан байна. | Тус онд 3 аж ахуйн нэгж, 2 иргэн 2 га талбайд 2000 ширхэг /улиас, хайлаас/ ойн зурвас шинээр байгуулсан. | 70.0 |
| **Зорилт 19. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сайжруулна.** | | | | | | | |
| 19.1 | **Арга хэмжээ-69**<br>"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өрнүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх | 1000,0 | Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, мян. тн, хүн амын хэрэгцээ хангамжийн хувь | - | Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлт, хүн амын хэрэгцээ хангамжийн хувь урд оноос өссөн байна. | Сумын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний тэнцлийг жилийн эцсийн байдлаар тооцож, Өвөрхангай аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.<br>Мөн хүнсний нөөцийн мэдээг 7 хоног бүр хүнсний бөөний төв болон худалдаа эрхлэгч 21 дэлгүүрээс тусгай маягтын дагуу авч программд тухай бүр нь шивж оруулсан ба сумын хүнсний нөөцийн хангамж, нөөц хангалттай байгаа бөгөөд нөөцийн баталгаат байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>Тус худалдааны төвөөр дамжуулан 3 иргэн гурил гурилан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, сувинер, гар урлалын чиглэлээр бүтээгдэхүүнээ борлуулж 11.3 сая төгрөгийн борлуулалт хийгдэж 1 иргэнийг ажлын байраар хангаж ажилласан.<br>Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/95 дугаар захирамжаар Хоршоог хөгжүүлэх сангаас цэвэр усны үйлдвэрийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөтгөх чиглэлээр 1 хоршоонд 125,0 сая төгрөгийн дэмжлэгт хамруулж 780 гаруй айл өрх, 70 гаруй төрийн болон төрийн бус байгууллагад цэвэр усыг түгээж, 6,6 сая төгрөгийн борлуулалт хийж 3 иргэнийг түр болон байнгын ажлын байраар ханган ажиллаж байна | |
| **Зорилт 20. Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хоршоодыг чадавхжуулна.** | | | | | | | |
| 20.1 | **Арга хэмжээ-70**<br>"Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, орон нутагт сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах | - | -Зохион байгуулсан арга хэмжээний тоо,<br>-Олон нийтэд хүргэсэн мэдээллийн сувгийн тоо<br>-Хамрагдсан иргэдийн тоо | | "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг орон нутагт сурталчлан таниулах арга хэмжээг 3-аас доошгүй, мэдээллийн сувгаар 10-аас доошгүй удаа сурталчилсан байна. | "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлээр, 3 аж ахуйн нэгж, 1 иргэн үйл ажиллагаа явуулж, 9 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж байна.<br>"Алга дүүрэн" хоршоо 6,3 тн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн худалдаанд гаргалаа.<br>Энэ онд 3 аж ахуй нэгж 70,3 тонн ноосыг худалдан авч анхан шатны тордолт хийж 13 иргэнийг түр ажлын байраар ханган ажиллалаа. | 90.0 |
| 20.2 | **Арга хэмжээ-71**<br>"Шинэ-Хоршоо" хөдөлгөөнийг эрчимжүүлж, санал санаачилгатай малчдыг бүх талаар дэмжих, холбогдох ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран хоршоодыг чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | - | -Дэмжлэгт хамрагдсан хоршооны тоо,<br>-Хөнгөлөлттэй зээлийн хэмжээ (тэрбум төг)<br>-Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ,<br>-Хамрагдсан хоршоодын тоо | - | Хөнгөлөлттэй зээлийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, чадавхжуулсан байна. | "Шинэ-Хоршоо хөдөлгөөнийг эрчимжүүлж, Хөгшний гол, Хан бургатайн хишиг, Усан хавтгайн хишиг, Үржин дэлгэрэх өвөр элстэй, Баян мал аж ахуйн , Баяжих бат тулга, Цэцэгт сайхан тал ундарга 8 хоршоодод тус бүр 5 га газрыг эзэмшүүлээд байна. Шинээр хоршоо байгуулах болон хоршооны гишүүн болох хүсэлтэй 28, иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг өгч ажилласан.<br>Мөн Архангай аймагт зохион байгуулагдсан хоршоологчдын хангайн бүсийн зөвлөгөөнд "Баяжих бат тулга", Зөөлөн сувд" хоршоо оролцож сайн туршлагын талаар мэдээлэл хийлээ. | 90.0 |
| **Зорилт 21. Мал эмнэлгийн салбарын чиглэлээр** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21.1 | **Арга хэмжээ-72**<br>Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, гоц халдварт, халдварт өвчний голомтын, сэжигтэй бүсийн бэлчээр, ус эх булаг, малын өвөлжөө, хаваржаа, хэвтэр бууц, хашаа хороог цэвэрлэх, халдваргүйтгэх арга хэмжээг зохион байгуулах | - | Хэрэгжилтийн хувиар | 100 | 100 | Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/64 дүгээр захирамжаар төлөвлөгөөт халдваргүйтгэл, сэг устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан 8 багийн хэмжээнд 149 толгой малын хорогдолтойгоор мэдээллэгдэж 2025 оны 05 дугаар сарын 08, 09 ний өдрүүдэд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж сэг зэм устгалыг удирдах ажилтан 1, малын их эмч 3, Засаг даргын тамгын газрын 10 албан хаагч, туслах ажилтан 10 хүний бүрэлдэхүүнтэй Шанхын гол, Орхон гол, Хөгшин орхон голыг ай сав дагуух адуу 9, үхэр 7, хонь 87, ямаа 39 нийт 142 малын сэг зэмийг хогийн нэгдсэн төвд цуглуулан устгаж 95 хувийн гүйцэтгэлтэй байна. Мал эмнэлгийн устгалын цэгийн 768м.кв, хашаа хорооны 2100м.кв нийт 2788м.кв талбайг халдваргүйтгэсэн байна. Халдваргүйтгэлийн арга хэмжээнд хашаа хорооны халдваргүйтгэл 100 өрхийн 70,000 м.кв, бэлчээрийн талбайн 2000 м.кв нийт 72,000 м.кв талбайг халдваргүйтгэсэн. | 100 |
| 21.2 | **Арга хэмжээ-73**<br>"Эрүүл сүрэгтэн" хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүлийг баталгаажуулах | | | | | Үхэр сүргийг бруцеллёз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах туршилтын хөтөлбөрт сонгогдсон Орхон, Эрдэнэтолгой багийн 30 малчин өрхийн саалинд хамрагдаж буй 140 үнээний сүү, баасны дээжийг шинжилгээнд, эрт илрүүлгийн үзлэгт 100 үхэр хамруулах ажлыг зохион байгуулсан. Сонгогдсон 30 өрхийн шинжилгээнд хамрагдсан сүүний дээжинд бруцеллёз илрээгүй. | 90.0 |
| **ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЛБАР** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 22.1 | **Арга хэмжээ-74**<br>Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор батлсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх | 5000,0 | Тарьсан модны тоо Амьдралтын хувь хэмжээ: | 22390 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумдад мод тарих төлөвлөгөөний дагуу | Бүх нийтийн мод тарих хөдөлгөөн өрнүүлэх тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулах ажилд байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн талбайд 300 ширхэг, тариалангийн талбайн хашаанд 500 ширхэг, айл өрхүүд 1200 ширхэг, ААН, байгууллагууд өөрийн эзэмшил газартаа 6060 ширхэг, нийт 8060 ширхэг мод бут тарьлаа.<br>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 9,0 орон нутгийн төсвийн 29,9 сая, нийт 38,9 сая төгрөгийн санхүүжилтээр ногоон байгууламжийг хамгаалах хашааны материалыг "Мандах төгс гурван эрдэнэ" ХХК нийлүүлсэн.<br>Шинэ Хархорин хотын захиргаанаас "Онгоцон Ухаа" багийн "Харганат" гэх газарт 700,000 мод тарьж, хашаажуулан, усалгааны 60 ширхэг гүний худаг гаргасан.<br>Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас Мойлтын аманд ойжуулалтын 15 га талбайд 8000 ширхэг мод тарьсан. | 100 |
| 22.2 | **Арга хэмжээ-75**<br>Иргэд олон нийтэд экологийн боловсрол олгох, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд төрөл бүрийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | - | Сургалт сурталчилгааны тоогоор | 2 | 5 | Өвөрхангай аймгийн Байгаль орчны газар, орон нутгийн өмчит Хархорин-Ус суваг ХХК-тай хамтарч ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан байгаль орчны тухай хуулийн багц сургалтыг зохион байгуулсан. Нийт 150 гаруй хүүхэд, залуучууд хамрагдлаа.<br>Нийт иргэдийн дунд "Мөнх цас, мөсөн голыг хамгаалан авч үлдье" сэдэвт видео контентын уралдаан зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа. | |
| 22.3 | **Арга хэмжээ-76**<br>Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөг батлуулсан эсэх | - | Төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна | Аймгийн төлөвлөгөөнд нийцүүлэн ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувьтай байна. | 70.0 |
| 22.4 | **Арга хэмжээ-77**<br>Булгийн эхийг хашиж хамгаалах шаардлагатай булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах | - | Хашиж хамгаалсан булаг шанд, рашааны тоо | 8 | 8 | Орон нутгийн хөгжлийн сангийн 18,0 сая төгрөгийн санхүүжилтээр Чулуун хороот, Дээд хүзүүвч, Урд тариат, Өвөр булаг Цохион бүрд, Сүүжийн рашаан нийт 6 булгийн эхийг хашиж хамгаалсан. | 100 |
| 22.5 | **Арга хэмжээ-78**<br>Нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах | - | Биотехникийн арга хэмжээг зохион байгуулсан үр дүн, давтамж, тоо хэмжээгээр | 1 | 2 | Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 1,5 сая төгрөгийн санхүүжилтээр Жалбаа багийн "Их эрээн уул"-ын зэрлэг амьтдын 3 цэгт, Орхон багийн "Баянзүрх хайрхан"-ны 2 цэгт 45 боодол өвс, 600 кг хужир тавьж биотехникийн арга хэмжээ авлаа. | 100 |
| 22.6 | **Арга хэмжээ-79**<br>Шонхор шувууг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх хүрээнд цахилгаан дамжуулах шугамын тулгуурын тусгаарлагч болон хиймэл үүр, суудал хийх | - | Хийж байрлуулсан хиймэл үүр, суудлын тоо | - | Шонхор шувууг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. | - | - |
| **НАЙМ.ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 23. Газрын харилцааны салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 23.1 | **Арга хэмжээ-80**<br>Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, оруулах | - | Системийн хэрэглэгчид | - | Нэгж талбарын хувийн хэргийн цаасан баримтыг мэдээллийн санд бүрэн оруулах ажилд Засаг аргын Тамгын газраас ажлын хэсэг | Газар эзэмшигч, өмчлөгч 1639 нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн сангийн системд холбогдох журмын дагуу бүртгэж, оруууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гарган хамтран бүртгэсэн байна. | | |
| 23.2 | **Арга хэмжээ-81**<br>Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардал, техник хэрэгслийг шийдвэрлэх | 1200,0 | Мониторингийн цэгийн тоо | | Сумын бэлчээрийн газрыг фотомониторингийн аргаар тодорхойлох | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хэсгийг сумын засаг даргын А/145 дугаар захирамжаар байгуулж өвөл, хавар, зун намар, отрын нөөц нутаг, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг төлөөлөхүйц 22 цэгээс ургамлын бүрхэц, биомасс, элэгдэл эвдрэл, идэгдэц зэрэг үзүүлэлтээр нь хариуцуулан даац багтаамжийг тодорхойлов. Ургамлын бүрхэц, биомасс, элэгдэл эвдрэл, идэгдэц зэрэг үзүүлэлтээр нь харьцуулан даац багтаамжийг тодорхойлсон.<br>Байгалийн бүс, бүслүүрээр нь авч үзвэл ойд хээрийн бүсэд 7 цэг, хээрийн бүсэд 15 цэгээс 2025 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газарт хүргүүлсэн. | 100 |
| **ЕС. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР** | | | | | | | |
| **Зорилт 24. Хөдөлмөрийн харицааны талаарх авах арга хэмжээ** | | | | | | | |
| 24.1. | **Арга хэмжээ-82**<br>Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформыг тухайн орон нутгийн ажил олгогч, ажил хайгч, иргэд, олон нийтэд танилцуулж сурталчлах | - | Иргэд, олон нийтэд танилцуулж сурталчлах | - | Гүйцэтгэлийн хувиар | Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформыг kharkhorum.mn цахим хуудас, Хархорин мэдээ фэйсбүүк хаягаар болон гарын авлагаар иргэд, олон нийтэд танилцуулж сурталчлан ажиллалаа. Ажил хайгч 175 иргэдийн ур чадварт үнэлгээ өгч Ejob программд орууллаа. | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24.2. | **Арга хэмжээ-83**<br>Төрийн байгууллага, орон нутгийн бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах замаар шинэ ажлын байр бий болгох | - | -Шинээр бий болсон ажлын байрны тоо<br>-Байнгын 30 хувь<br>-Улирлын 30 хувь<br>-Түр 40 хувь | - | -Байнгын 30 хувь<br>-Улирлын 30 хувь<br>-Түр 40 хувь | Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагад ажил хайгч иргэдийг зуучилж, төсөл хөтөлбөрийн хүрээнд байнгын 87, улирлын 116, түр 161 ажлын байр, нийт 364 ажлын байр бий болсон. | 90.0 |
| 24.3 | **Арга хэмжээ-84**<br>Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг дэмжих, хөдөлмөрийн харилцаа, цалин, хөлсний олголтод зөвлөн туслах, сургалт, төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулах | - | 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна | - | 2 | Хувийн хэвшлийн байгууллагуудын хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний олголттой холбоотой өргөдөл гомдол гараагүй болно.<br>Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл, үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран төрийн 9 байгууллага, шинээр баригдаж байгаа 7 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн заавар зөвлөмж өгч ажилласан. | 90.0 |
| **Зорилт 25. Нийгмийн хамгаалал, нийгмийн бүлгүүдэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэж, гомдол чирэгдэлгүй ажилласан байна.** | | | | | | | |
| 25.1 | **Арга хэмжээ-85**<br>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хоршоо хөгжүүлэх сан болон бусад төсөл арга хэмжээнд хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх | - | Бий болсон ажлын байрны тоо | - | Гүйцэтгэлийн хувиар | Өвөрхангай аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга, сумын Засаг даргын хамтран ажиллах гэрээний дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төслийн хүрээнд мод тарилт, сумын төвийн ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлэгээ, хайс хашаа шилжүүлэн барих ажилд 11 иргэнийг хамруулан хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган, өдөр тутмын ажилд үүрэг чиглэл өгч хяналт тавин 8 хоног ажилуулсан.<br>4,160,000 төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Иргэний санхүүгийн дэмжлэгт 2 иргэнд 10,0 сая, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 2 иргэнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10,0 сая, Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд 5,0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэг олгосон. | |
| 25.2 | **Арга хэмжээ-86** Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт нөлөөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | 3000,0 | Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна | - | Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна | Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг нийт 12 удаагийн давтамжтайгаар "Хархорин мэдээ" фэйсбүүк хуудас болон сумын зарын группүүдэд байршуулж, олон нийтийг идэвхтэй оролцохыг уриалан ажилласан. Уг мэдээллүүд нь нийт 22,000 удаагийн хандалт авч, иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд бодитой нөлөө үзүүлсэн. Өсвөр насны хүүхдийн зөрчигдсөн болон хөндөгдсөн гэмт хэрэг зөрчлийн талаар "Хуулийн цаг" подкастыг бэлтгэж, Хархорин мэдээ фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэж, 7,5 мянган удаагийн хандалт авсан. Олон улсын охидын өдрийг тохиолдуулан ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудтай хамтран "Кофетой ярилцлага", "Охидын шивнээ", "Pink Day" зэрэг охидын эрх, аюулгүй байдлыг дэмжих арга хэмжээнүүдийг зохион байгуулж, нийт 360 охидыг хамрууллаа. Ээж, охидын харилцааг бэхжүүлэх, охидын өөрийгөө хамгаалах чадвар, эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор "Barbie Event" арга хэмжээг зохион байгуулж, эерэг харилцаа, дэмжлэгийн орчныг бүрдүүлэн ажиллав. | 90.0 |
| **АРАВ. ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ** | | | | | | | |
| **Зорилт 26. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал** | | | | | | | |
| 26.1 | **Арга хэмжээ-87** Гэр бүлийн үнэ цэн, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр | - | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 30.0 хувь | "Халуун ам бүл" төслийн хүрээнд хөтөлбөрийн хувийн хэргийг нээн Хүүхэд хамгааллын явуулын | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлийн хүчирхийллийг бууруулах хүрээнд “Халуун ам бүл” төслийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | | | | | үйлчилгээг зохион байгуулж, нийт 7 байгууллагын 99 албан хаагчид Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын бодлого болон Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг танилцуулан, хэрэгжилтийг хангах зөвлөмж өгч ажиллалаа. Мөн Халуун ам контентын уралдаанд нэг гэр бүлийг оролцуулсан байна.<br><br>“Хүүхэд хамгаалал ба кейс менежмент” сэдэвт сургалтад хамтарсан багийн 15 гишүүн, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтан, арга зүйч, сэтгэлзүйчийг чадавхжуулах сургалтад 13 албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Цагдаагийн хэлтэстэй хамтран архины хамааралтай 12 иргэнийг сургалтад хамруулж, гэр бүлийн хүсэлт болон өөрийн хүсэлтээр архинд донтох 3-р зэрэгтэй 4 иргэнийг эмчилгээнд хамруулсан.<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран, Хамтарсан багийн хамгааллын 1,650.0 мянган төгрөгийн санхүүжилтээр “Аз жаргалтай гэр бүл” вакум сургалтыг зохион байгууллаа.<br>Сургалтад сумын хэмжээнд сонгогдсон 10 гэр бүлийн 20 иргэн хамрагдаж, гэр бүлийн харилцаа, харилцан хүндлэл, хүүхэд хүмүүжлийн арга барил, эерэг харилцааг төлөвшүүлэх чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна. | |
| 26.2 | **Арга хэмжээ-88**<br>Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс урьдчилан | - | Төслийн хэрэгжилтийн хувь | - | 30.0 хувь | “Хайрлагдсан хүүхэд” төслийн хүрээнд “Зөв таниас эхлэнэ” хүүхдийн чуулганд Ерөнхий боловсролын сургуулийн 9– | 90.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах "Хайрлагдсан хүүхэд" төслийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | | | | | 12 дугаар ангийн 12 сурагчийг хамруулж, Засаг даргын Тамгын газраас 500,0 мянган төгрөг зарцуулсан. Зорилтод өрхийн 13 хүүхдийг "Цагаан залаа" төвд, Хүүхдийн өөрөө удирдах байгууллагын 13 хүүхдийг "Найрамдал" хүүхдийн зусланд амрааж хөгжлийн үйлчилгээ үзүүлсэн. Өсвөр насны хүүхдийн эрхийн хөндөгдсөн болон зөрчигдсөн асуудлын талаар "Хуулийн цаг" подкастыг Хууль эрх зүйн мэргэжилтэн болон Улсын өмгөөлөгч нартай хамтран бэлтгэж олон нийтэд түгээсэн. Хүүхэд хамгааллын "Солонго" төвийн хүүхдийн хүнсний хангамж, хоол үйлдвэрлэл болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас олгодог хоолны норматив зардлын зарцуулалтын тайлантай танилцаж зөвлөмж өгч ажилласан. "Хүүхдээ сонсох өдөр"-ийг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 9–12 дугаар ангийн 80 сурагчийг хамруулан шийдвэр гаргагчид уламжилсан. "Зөв дадал–Эрүүл ирээдүй" сэдэвт хүүхдийг хорт зуршил, архи, согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи, мансууруулах бодис хэрэглээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн эрхийг хамгаалах сургалтад 65 иргэнийг хамруулж мэдээлэл, зөвлөмж өгсөн. | |
| **Зорилт 27. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах** | | | | | | | |
| 27.1 | **Арга хэмжээ-89**<br>Сумын жендэрийн дэд зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | - | -Дэд зөвлөл<br><br>-Арга хэмжээний гүйцэтгэлээр | - | 13 | "Жендер -Өв" хөтөлбөрийн хүрээнд 2025 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. "Харилцаа хүндэтгэе" аяны хүрээнд сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулан 12 байгууллагын 25 албан хаагч оролцлоо. Хархорин фэйсбүүк хуудсаар “Харилцан хүндэтгэе” аяны уриа үгс, лого гэх мэт сурталчилгааны 4 төрлийн зурагт хуудас бэлтгэн байршуулсан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, монгол цэргийн өдрийг тохиолдуулан жендерийн хорооноос жил бүр зохион байгуулдаг “Харилцан хүндэтгэе” 1 сарын аяныг “Хайраа хайрлъя, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлье” уриатайгаар зохион байгуулж “Жендерт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан”, эмэгтэйчүүдэд зориулсан “Өөрийгөө хайрлахуй”, “Хайраа хайрлая” сэдэвт гэр бүл рүү чиглэсэн сургалт зохион байгуулагдлаа. Нийт 60 иргэн хамрагдлаа. | |
| **Дундаж үнэлгээ** | | | | | | | **92,6** |

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.НЯМДАВАА

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА Б.БАТ-ЭРДЭНЭ